




МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх ба тээвэрлэлтэд
зуучлах үйлчилгээ



Албан хэвлэл

Стандарт, хэмжил зүйн газар
Улаанбаатар хот
2017 он

ӨМНӨХ ҮГ

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ) нь Олон Улсын Стандартчиллын байгууллагын гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран үндэсний стандартчиллын бодлогыг хэрэгжүүлэх ажил эрхэлдэг.

Стандартын төсөл боловсруулах ажлыг салбарын стандартчиллын Техникийн хороо (ТХ), Дэд хороо (ДХ) эрхлэн гүйцэтгэдэг бөгөөд Техникийн хорооны хурлаар хэлэлцэж 75 хувиас доошгүй дэмжиж зөвшилцсөн төслийг Стандартчиллын үндэсний зөвлөлөөр хэлэлцэн, тогтоолоор баталснаар хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартыг Техникийн ухааны доктор (Ph.D) Д.Ганбаатар, Эдийн засгийн ухааны доктор Л.Түдэв, Монгол улсын зөвлөх инженер Б.Батбаяр, Зөвлөх эдийн засагч Ц.Содов нар шинээр боловсруулж, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Автотээврийн газар, "МОНТРАНС" Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбооны "Шинжилэх ухаан технологийн зөвлөл"-ийн хамтарсан хуралд хэлэлцүүлэн боловсруулж, Стандарт, хэмжил зүйн газрын 2017 оны стандартчиллын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу шинэчлэн боловсруулав.

Уг стандартын төслийг СХЗГ-ын дэргэдэх Авто тээврийн стандартчиллын техникийн хороо (ТХ15)-оор хэлэлцэж зөвшилцсөн болно.

Энэхүү стандартыг СХЗГ-ын стандартын шинжээч, мэргэжилтэн Д.Төрмөнх Монгол Улсын стандартчиллын тогтолцооны суурь стандарт MNS 1.1 : 2006, MNS 1.2 : 2006-ын дагуу хянав.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энх тайваны өргөн чөлөө 46А

Шуудангийн хаяг

Улаанбаатар-13343, Ш/Х - 48

Утас: 976-51-263860, 51-266754, Факс: 976-11-458032

E-mail: standardinform@masm.gov.mn

www.estandard.gov.mn

© СХЗГ, 2017

"Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай" Монгол Улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн, эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-т байна.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ


Ангилалтын код 03.220.20; 43.040.01

Автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх ба тээвэрлэлтэд зуучлах үйлчилгээ	MNS 5346 : 2017
Transportation and freight forwarding services for motor vehicles	MNS 5346 : 2003 ононд

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 54 дүгээр тогтоолоор батлав.

Стандарт нь 2018 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

Стандартын үзүүлэлт, шаардлагыг заавал мөрдөнө.



1. Зорилго

Стандартын зорилго нь автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх, зуучлах үйл ажиллагаанд тавих шаардлагыг тодорхойлох, түүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2. Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэгч аж ахуйн нэгж байгууллага, болон тээвэрлэгч, тээвэрлүүлэгч, зуучлагч, ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий хяналтын байгууллага, албан тушаалтанд хамаарна.

3. Норматив эшлэл

3.1. Энэхүү стандартад эш татаж хэрэглэсэн доорх баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны эх материалаас иш татаж хэрэглэнэ. Үүнд:

- MNS 4978 : 2000 - Аюултай ачаа. Ангилал. техникийн шаардлага
- MNS 4643 : 1998 - Хөдөлмөр хамгаалал. Аюулгүй ажиллагааны таних тэмдэг, тэмдэглэгээ
- MNS 4999 : 2000 - Галын аюултай бүтээгдэхүүний ангилал, зэрэглэл.
- MNS 5566 : 2005 - Галын аюулаас хамгаалах хэрэгсэл. Аж ахуйн нэгж байгууллага барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага.
- MNS 5343 : 2011 - Хүнсний түргэн гэмтэх, эмзэг бүтээгдэхүүнийг тээвэрлэх. Ангилал, ерөнхий шаардлага.
- MNS ISO 780 : 2004 - Баглаа боодол. Эд зүйлсийг зөөвөрлөхөд тавих шаардлага.
- ГОСТ Р 52298 : 2004 - Услуги транспортно-экспедиторские..
- БНБД32.01.04 - Авто зам төсөллөх..
- MNS 4598 : 2011 - Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага.

4. Нэр томьёо

4.1.

Ачаа

Автотээврийн хэрэгслээр тээвэрлэж буй эд зүйлс

4.2.

Ачаа тээвэрлэлт

Автотээврийн хэрэгслээр ачааг нэг газраас нөгөө газарт шилжүүлэн зөөх ажил үйлчилгээ

4.3.

Автотээврийн хэрэгсэл

Ачаа тээвэрлэхэд зориулсан бүх төрлийн ачааны автомашин, чирэгч, чиргүүл, хагас чиргүүл

4.4.

Тээвэрлүүлэгч

Тээвэрлэлтийн үйлчилгээ хэрэглэгч

4.5.

Тээвэрлэгч

Ачаа тээвэрлэлтийн ажил үйлчилгээ эрхэлж байгаа этгээд

4.6.

Тээвэр-зуучлагч

Тээвэрлүүлэгч, тээвэрлэгчдийн хооронд зуучлан үйлчилж байгаа этгээд

4.7.

Шуурхай тээвэрлэлт

Захиалагчийн шаардлагаар богино хугацаанд гүйцэтгэх тээвэрлэлт.

5. Ачаа тээврийн үйлчилгээний ангилал, тавих шаардлага

5.1. Ачааг түүний шинж чанар, тоо хэмжээнд тохирох зориулалтын автотээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

5.2. Ачаа тээвэрлэлтийг хамрах нутаг дэвсгэрийн хүрээгээр нь дараах төрөлд ангилна. Үүнд:

- Улс хоорондын болон дамжин өнгөрөх тээвэрлэлт;
- Хот хоорондын тээвэрлэлт;
- Орон нутгийн тээвэрлэлт;
- Хот доторх болон хот орчмын тээвэрлэлт;

5.3. Ачааг тэдгээрийн физик, механик шинж чанар, овор хэмжээ, тээвэрлэлтийн нөхцөл, тээвэрлэлтэд тавих шаардлага зэргээс хамааруулж дараах төрөл ангилалд хуваана. Үүнд:

а/ ачааны төрлөөр:

- Ердийн ачаа
- Үйрмэг ачаа
- Шингэн ачаа
- Урт, хүнд, овор ихтэй ачаа

- Амьд мал, амьтан
- Аюултай ачаа.

б/ Ачааны шинж чанараар нь:

- Аж үйлдвэрийн өргөн хэрэглээний бараа (төрөл бүрийн бэлэн хувцас, бөс бараа, гэр ахуйн бараа, тавилга г.м.)
- Хүнсний өргөн хэрэглээний бараа (гурил, будаа, элсэн чихэр, ургамлын тос, архи, пиво, ундаа, талх нарийн боов г.м.)
- Хөдөө аж ахуйн бараа (үр тариа, төмс хүнсний ногоо, өвс тэжээл, бордоо, арьс шир, ноос ноолуур, түүхий эд, мал амьтан г.м.)
- Түргэн гэмтэх, эмзэг хүнсний бараа (мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, загас, өндөг, жимс жимсгэнэ г.м.)
- Барилгын материал (тоосго, цемент, шохой, угсармал төмөр, бетонон эдлэл, зуурмаг, элс хайрга, мод зүсмэл материал г.м.)
- Уул уурхайн үйлдвэрийн бүтээгдэхүүн (нүүрс, жонш, хүдэр, хүдрийн баяжмалууд г.м.)
- Техникийн бараа, машин тоног төхөөрөмж
- Нефть, нефтийн бүтээгдэхүүн.

5.4. Ачаа нь автомашины даац ашиглалтаас хамаарч 3 зэрэглэлтэй байна.

Даац ашиглалтын коэффициент нь автотээврийн хэрэгслийн үйлдвэрлэгчээс тогтоосон даацыг ачсан ачааны хэмжээнд харьцуулсан харьцаагаар тодорхойлоно.

1-р хүснэгт

Зэрэглэл	Даац ашиглалт
I. зэрэглэл	0,95-1,0
II. зэрэглэл	0,71—0,95
III. зэрэглэл	0,51—0,70;

5.5. Ачааны зэрэглэлээс хамааруулан тээврийн хөлсний тарифыг тогтооно.

5.6. Ачааны төрөл, ангилал тус бүрээр тээвэрлэлтийн нөхцөл, тавигдах шаардлагыг Монгол Улсын үндэсний стандартаар тогтооно.

5.7. Ачааны төрөл, ангилал нь хөдлөх бүрэлдэхүүний зориулалт, төрлийг сонгох үндэслэл болно.

5.8. Ачаа тээвэрлэлтийн гэрээгээр тээвэрлэгч нь ачааг тогтоосон газар хүргэх, тээвэрлүүлэгч нь хэлэлцэн тохирсон хөлс төлөх, ачааг тээвэрлэлтэд бэлтгэх, хүлээн авах үүргийг тус тус хүлээнэ.

5.9. Тээврийн үйлчилгээний үнэ хөлсний жишиг тариф, тээвэрлэлтийн баримт бичгийг батлагдсан загварын дагуу ашиглана.

5.10. Авто зам, замын байгууламжийн бүрэн бүтэн байдал, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүднээс автотээврийн хэрэгслийн даац, түүний нэг тэнхлэг дээрх ачааллын норматив хэмжээг хэтрүүлэхийг хориглоно.

6. Ачаа тээвэрлэх үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, тавих шаардлага

6.1. Ачаа тээвэрлэх үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага нь:

6.1.1. улсын бүртгэлд бүртгүүлж улсын бүртгэлийн гэрчилгээ авсан байх;

6.1.2. татвар төлөгч байх;

6.1.3. үйл ажиллагаа нь ачаа тээврийн үйлчилгээний чиглэлээр мэргэшсэн байх;

6.1.4. стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн хүрээнд тохирлын үнэлгээнд хамрагдсан байх зэрэг шаардлагуудыг хангасан байвал зохино.

6.2. Захиалгат буюу гэрээт ачааг зориулалтын тээврийн хэрэгслээр тогтоосон хугацаанд хүлээн авах газарт нь тоо хэмжээ, чанар байдлыг алдагдуулахгүй бүрэн бүтэн хүргэнэ.

6.3. Тухайн төрөл, ангиллын ачааг зөвхөн зориулалтын шаардлага хангасан автотээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

6.4. Ачаа тээвэрлэх үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага нь тээврийн хэрэгслийн техникийн бэлэн байдлыг хангах зохих хэмжээний засвар, үйлдвэрлэлийн байр, гарааш, зогсоол талбай, тоног төхөөрөмж, мэргэжлийн ажиллах хүчнээр хангагдсан байна.

6.5. Автотээврийн асуудал эрхэлсэн төв ба орон нутгийн байгууллагаас тээвэрлэгчдийг тээвэрлэлт гүйцэтгэх нөхцөл боломж бүрдүүлсэн байдлаар нь зэрэглэл тогтооно.

6.6. Ачаа тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага нь автотээврийн хэрэгслийн тоо, материаллаг бааз, санхүүгийн чадавх, мэргэжилтэй боловсон хүчний байдал зэргээс хамааран "А", "В", "С", "D" гэсэн зэрэглэлтэй байна.

**2-р хүснэгт - Ачаа тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн
нэгж, байгууллагын зэрэглэл**

Зэрэглэл	Тавих шаардлага			
	Автотээврийн хэрэгслийн зориулалт, тоо хэмжээ, эзэмшил	Үйлдвэрлэлийн бааз, техник хангамж	Санхүүгийн чадавх	Инженер, техникийн ажилтны тоо
"А"	Бүх төрлийн ачаа тээвэрлэх зориулалтын /101-ээс дээш/ өөрийн эзэмшлийн	Өөрийн буюу гэрээт гарааш, зогсоол, засвар, үйлчилгээний байр, ажилчдын амрах байртай байх	Нийт тээврийн хэрэгслийн үнийн дүнгийн 20%-аас багагүй эргэлтийн хөрөнгөтэй байна.	4 ба түүнээс дээш
"В"	Нэг буюу хэд хэдэн төрлийн ачаа тээвэрлэх зориулалтын, /51-100/өөрийн эзэмшлийн	Өөрийн буюу гэрээт гарааш, зогсоол, засвар, үйлчилгээний байр, ажилчдын амрах байртай байх		3 ба түүнээс дээш
"С"	Ердийн, үйрмэг буюу шингэн ачаа тээвэрлэх зориулалтын, /21-50/ өөрийн ба бусад эзэмшлийн			2 ба түүнээс дээш
"D"	Ердийн ачаа тээвэрлэх зориулалтын, 5-20 хүртэл өөрийн ба бусад эзэмшлийн			1 ба түүнээс дээш байна.

ЖИЧ: Улс хоорондын байнгын ачаа тээвэр болон дамжин өнгөрөх ачаа тээвэрлэлт гүйцэтгэх тээвэрлэгч нь зөвхөн өөрийн өмчлөлийн автотээврийн хэрэгсэлтэй байна.

6.7. Автотээврийн хэрэгслийн жолооч нь тухайн ангиллын жолоодох эрхийн болон мэргэшсэн жолоочийн мэргэжлийн үнэмлэхтэй байна.

6.8. Ачаа тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж нь зэрэглэлдээ тохирсон инженер-механик, техникийн ажилтнуудтай байна. Инженер, техникийн ажилтан байна. Үүнд:

- Авто инженер/бакалавр болон түүнээс дээш төвшний боловсролтой/
- Засварын болон хяналтын механик, тээвэр зохицуулагч /бакалавраас дээш төвшний боловсролтой/
- Мэргэжлийн үнэмлэх бүхий засварын ажилтнууд зэрэг багтана.

6.9. “А”, “В”, “С” зэрэглэлийн тээвэрлэгч аж ахуйн нэгж нь хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа хариуцсан орон тооны мэргэжлийн ажилтантай байна.

7. Ачаа тээвэрлэлтэд зуучлагч байгууллагад тавих шаардлага

7.1. Тээвэр зуучлагч нь тээвэрлүүлэгчийн ачааг илгээх цэгээс хүрэх цэгт нэг буюу хэд хэдэн тээвэрлэгчээр дамжуулан хүргэж болох бөгөөд дараахь шаардлагуудыг хангасан байвал зохино.

7.1.1. Улсын бүртгэлийн гэрчилгээнд тээвэр зуучийн үйлчилгээ эрхлэх талаар бүртгэлийг хийлгэсэн байх;

7.1.2. Татвар төлөгч байх;

7.1.3. Зуучлалын үйл ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байх;

7.1.4. Албан ажлын болон үйлчилгээний барилга байгууламж, мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан, мэдээлэл холбооны сүлжээнд холбогдсон байх;

7.1.5. Стандарчилал, тохирлын үнэлгээнд хамрагдсан байх.

7.1.6. Зуучлалын үйл ажиллагаа эрхлэх санхүүгийн чадамжтай байх зэрэг шаардлагуудыг хангасан байвал зохино.

7.2. Зуучлалын үйл ажиллагааг салбар агентаар харилцан тохиролцсон гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

7.3. Тээвэр зуучлагчийн буруутай үйл ажиллагаанаас ачааг бэлтгэн нийлүүлэгч, хүлээн авагч, тээвэрлэгчид учирсан хохирлыг холбогдох хуулийн дагуу шийдвэрлэнэ.

7.4. Тээвэр зуучлалын үйлчилгээ нь дараах төрөлтэй байж болно.

- Бараа бүтээгдэхүүнийг худалдан авах гэрээ байгуулахад оролцох, зуучлах ;
- Баримт бичиг бүрдүүлэх, ачааг хүлээн авах, олгох
- Ачаа хэрэглэгчдэд шууд хүргэх, тэдгээрээс барааг хүлээн авч тээвэрлэх ажил эрхлэх;
- Ачааг ачих, буулгах болон агуулахын үйлчилгээ үзүүлэх;
- Тээвэрлэгч, тээвэрлүүлэгчдийг мэдээллээр хангах;
- Ачааны даатгал;
- Төлбөр тооцоо, санхүүгийн үйлчилгээ;
- Тээврийн хэрэгслийн болон ачааны гаалийн бүрдүүлэлт хийх;
- Бусад тээвэр зуучийн үйлчилгээ

ТӨГСӨВ.

**А Хавсралт
(Мэдээллийн)
Ачааны зэрэглэлийн талаарх мэдээлэл**

1 дүгээр зэрэглэлийн ачаанд:

2 болон 3 дугаар зэрэглэлд хамаардаггүй ачаа хамаарна

1.2. 2 дугаар зэрэглэлийн ачаа:

1.2.1. Үйлдвэрийн бараа:

- 1.2.1.1. төрөл бүрийн бараа (гагнуурын ба шалгаж хянах, дугуй нөхөх, кино, эмнэлэг, холбоо, зургийн аппарат, түүний сэлбэг)
- 1.2.1.2. гадуур дотуур бэлэн хувцас
- 1.2.1.3. гутал (эсгий, савхин гутал, шаахай зэрэг)
- 1.2.1.4. даавуун эдлэл (сүлжмэл, ноосон, торгон)
- 1.2.1.5. жижиг бараа (хайрцагтай, боодолтой)
- 1.2.1.6. малгай, төрөл бүрийн
- 1.2.1.7. мотоцикл, дугуй
- 1.2.1.8. гэр ахуйн болон албан ажлын хэрэгцээний цахилгаан хэрэгсэл
- 1.2.1.9. сургалтын үзүүлэн материал
- 1.2.1.10. шилэн хэрэгсэл (эмнэлэг, лабораторийн)
- 1.2.1.11. шүдэнз
- 1.2.1.12. шил шаазан эдлэл, 200 мм-ээс дээш диаметртэй шилэн хоолойнууд
- 1.2.1.13. эм
- 1.2.1.14. даацанд хүргэж давхарлаж ачих боломжгүй, лааз савтай, тосон ба шороон будаг, лак, олиф
- 1.2.1.15. савтай болон автоцистернтэй шатахуун, спирт, глицерин, олиф, битум, уусгагч хольцууд
- 1.2.1.16. хүрмэн чулуу, перлит, керамзит, полистрол
- 1.2.1.17. асбестан хоолой
- 1.2.1.18. хөнгөн бетон хоолой
- 1.2.1.19. хуудсан төмрөөр хийсэн агаар дамжуулах хоолой, салхивчны бусад эдлэлүүд
- 1.2.1.20. хөнгөн чанарын керамзит, гипс, хөнгөн бетон, үнс, модны үртэс, зоргодос гэх мэт материалаар хийгдсэн хамар хана, бамбай зулавч хавтангууд
- 1.2.1.24. руберойд, толь пергамин, гидрозол, шалны хулдаас, ханын цаас (обой)
- 1.2.1.22. хөнгөн цагаан сав суулга ба бусад эдлэл задгай болон хайрцагтай
- 1.2.1.23. хавиргат хавтан, ханын хавтгаалж, шатны марш, худгийн цагираг, онгоц гэх мэт овор ихтэй барилгын төрөл бүрийн бетонон төмөр хавтан
- 1.2.1.24. холбооны агаарын шугамын 6 метрээс дээш урттай модон шон
- 1.2.1.25. барилгын хаалга, цонх
- 1.2.1.26. төрөл бүрийн кабель утас
- 1.2.1.27. хуванцар эдлэл
- 1.2.1.28. шаазан вааран хоолой
- 1.2.1.29. гэрлийн бүрхүүл
- 1.2.1.30. сантехник, цахилгааны зарим тоноглол, хэрэгсэл
- 1.2.1.31. шугам хоолой
- 1.2.1.32. төрөл бүрийн хаалт, арматур

- 1.2.1.33. зуух, даралтат сав, насос
- 1.2.1.34. тоног төхөөрөмж, техник хэрэгсэл
- 1.2.1.35. дулаалгын материал
- 1.2.1.36. мэдээлэл, харилцаа холбооны суваг, сувагчлалын материал, хийц эдлэлүүд

1.2.2. Хөдөө аж ахуй, хүнсний бараа

- 1.2.1.1. гоймонгийн зүйл
- 1.2.1.2. сүү (автоцистернтэй)
- 1.2.1.3. талх (хайрцаг тавиур, контейнертэй)
- 1.2.1.4. хүнсний ногоо (төмс орохгүй)
- 1.2.1.5. хуурай жимс
- 1.2.1.6. хиам, хиаман бүтээгдэхүүн
- 1.2.1.7. хуурай сүү
- 1.2.1.8. бог малын хавсарсан ба гулууз мах

1.2.3. Бусад ачаа

- 1.2.3.1. яс
- 1.2.3.2. тарих бут сөөг
- 1.2.3.3. таар, шуудай, баглаа боодол болон бусад материалууд
- 1.2.3.4. хаягдал төмөр, төмрийн зоргодос
- 1.2.3.5. төрөл бүрийн савхи, нэхийгээр хийсэн хувцас
- 1.2.3.6. төмөр болон паалан сав суулга

1.3. 3 дугаар зэрэглэлийн ачаа:

- 1.3.1. барилгын дулаалгын шилэн хөвөн, хөөсөнцөр материал, хийцүүд
- 1.3.2. мебель, гэрийн эд хогшил, тооно
- 1.3.3. чийдэнгийн шил
- 1.3.4. өд, өдөн дэр
- 1.3.5. хөгжим, таазны чимэглэл
- 1.3.6. Төрөл бүрийн торх, лааз
- 1.3.7. модны үртэс, зоргодос
- 1.3.8. хайрцаг савтай нарийн боов, печень, торт
- 1.3.9. өндөг
- 1.3.10. архи, пиво, ундааны хоосон шил
- 1.3.11. төрөл бүрийн ангийн үс, үслэг эдлэл
- 1.3.12. ноос, ноолуур, хялгас, хөвөн (боодолтой)
- 1.3.13. сүрэл
- 1.3.14. өвс
- 1.3.15. уурын зуухны үнс, шлаг
- 1.3.16. хүүхдийн тоглоом (Хайрцаг савтай)